

# ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр  
төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зарцуулалт, хяналтыг  
хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Орон нутгийн хөгжлийн сангийн  
2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

### АУДИТЫН КОД: ДОА-2025/31-9-ШТА-ГА

Чойбалсан хот 2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер И.Сэмжидмаа  
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn  
Ахлах аудитор Я.Зориг  
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn  
Аудитор С.Энхбаатар  
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatars@audit.gov.mn  
Аудитор М.Ганбилэг  
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn  
Аудитор Ч.Ганбилэг  
Утас: 7058-4207, Цахим хаяг: udavlnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**АГУУЛГА**

|                                                                           |   |
|---------------------------------------------------------------------------|---|
| Товчилсон үгийн тайлбар.....                                              | 3 |
| Хүснэгт, дүрслэлийн товъёг.....                                           | 4 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл..... | 5 |

**БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн ч, хуваарийн дагуу олгох нөхцөл бүрдээгүй байна.....6**

|                                                                                                                                                                                           |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг Сангийн яам төвлөрсөн байдлаар тооцон боловсруулдаг тул орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй байна.....            | 6  |
| 1.1.2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу хуваарилж төлөвлөсөн ч зарим тохиолдолд хугацаа хоцроож олгосон... | 6  |
| 1.1.3. Тайлант онд ОНХС-ийн орлогын шилжүүлэг гүйцэтгэлдээ хүрээгүй нь сумдад орлогыг баталсан хуваарийн дагуу олгох нөхцөлийг бүрдүүлээгүй байна.....                                    | 7  |
| 1.1.4. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60.2.5-д үндэслэн судалж, уул уурхайн хандив тусламжаас орох 5,470.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөн ИТХ-аар батлуулсан байна.....      | 9  |
| 1.2.1. Төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн байна.....                                  | 10 |
| 1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн урт, дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна.....                        | 11 |
| 1.2.3. ОНХС-гийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.....                                                | 12 |
| 1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тухайн шатны чиг үүрэгт нийцүүлэн тусгасан байна.....                                                              | 14 |

**БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 94 хувьтай байна.....15**

|                                                                                                                                                                                                         |    |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 2.1.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....                                                                                                            | 18 |
| 2.1.2. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн журмын зөвшөөрөхгүй зардалд 2.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг зарцуулсан байна.....                                                                    | 19 |
| 2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 30 төсөл, арга хэмжээ байгаа нь нийт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 6 хувийг эзэлж байна..... | 19 |
| 2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд хувь нэмрээ өгсөн байна.....                                                     | 20 |
| 2.3.1. Сумын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 285.2 сая төгрөгийн 4 хөрөнгө бүрэн ашиглагдахгүй байна.....                                                                                             | 21 |
| 2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой түвшинд байна.....                                                                                                    | 21 |

**БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.....22**

|                                                                                                                                                                                                   |    |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 3.1.1. Аймгийн болон зарим сумдын ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна..... | 22 |
| 3.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг сумд хэрэгжүүлээгүй байна.....                                                                | 22 |
| 3.1.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь хэрэгжсэн байна.....                                                                                                                    | 23 |
| 3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн тайлагнаж ажилласан байна.....                                          | 23 |
| 3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.....                                                                                   | 23 |
| 3.2.3. ОНХС-ийн Удирдлагын нэгдсэн системд сангийн зарцуулалт болон үр дүнгийн талаар үнэн зөв, ил тод нээлттэй мэдээлээгүй байна.....                                                            | 24 |
| 3.2.4 Зарим сумд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроосон, огт байршуулаагүй тохиолдол гарсан байна.....                                      | 24 |

|                                              |       |
|----------------------------------------------|-------|
| Дүгнэлт:.....                                | 25    |
| ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....  | 26    |
| ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:..... | 27    |
| ЗӨВЛӨМЖ:.....                                | 28-31 |
| ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....          | 32    |

## Товчилсон үгийн тайлбар

|          |                                                        |
|----------|--------------------------------------------------------|
| ААНБ     | Аж ахуйн нэгж байгууллага                              |
| АМАТЗ    | Ашигт малтмал ашигласны тусгай зөвшөөрөл               |
| АМНАТ    | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр                  |
| АМХТЗ    | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл             |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт          |
| ГА       | Гүйцэтгэлийн аудит                                     |
| ГТНАТ    | Геологи, техникийн нөөц ашигласны төлбөр               |
| ГХБХБГ   | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар       |
| ДОА      | Дорнод аймаг                                           |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                              |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                           |
| НАА      | Нийтийн аж ахуй                                        |
| НДШ      | Нийгмийн даатгалын шимтгэл                             |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                              |
| ОНХНС    | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан                      |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                            |
| СТСХ     | Санхүү, төрийн сангийн хэлтэс                          |
| ТАХ      | Төсөл, арга хэмжээ                                     |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                            |
| ТӨХ      | Тендерийн өгөгдлийн хүснэгт                            |
| ТЭЗҮ     | Техник, эдийн засгийн үндэслэл                         |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                  |
| ХАА      | Худалдан авах ажиллагаа                                |
| ХБТХОХ   | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| ХХК      | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                   |
| ЦДАШ     | Цахилгаан дамжуулах агаарын шугам                      |
| ШТА      | Шууд тайлагналын аудит                                 |

**Хүснэгтийн товъёг**

| №         | Тайлбар                                                                                                                                | Хуудасны дугаар |
|-----------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Хүснэгт 1 | Дорнод аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрийн ангилал         | 6               |
| Хүснэгт 2 | Дорнод аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын батлагдсан хуваарь болон шилжүүлсэн хугацаа | 7               |
| Хүснэгт 3 | Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл”                                                                            | 8               |
| Хүснэгт 4 | Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт                                                                                        | 9               |
| Хүснэгт 5 | Орон нутгийн хөгжлийн сангийн сумдын орлогын төлөвлөлт                                                                                 | 9               |
| Хүснэгт 6 | Сумдын Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл                                                                          | 9               |
| Хүснэгт 7 | ОНХС-д иргэдийн саналын хэлбэр, тоо                                                                                                    | 10              |
| Хүснэгт 8 | Зорилтод үр дүнгийн судалгаа                                                                                                           | 19              |
| Хүснэгт 9 | Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт                                                                                                     | 23              |

**Дүрслэлийн товъёг**

| №         | Тайлбар                                                                                                             | Хуудасны дугаар |
|-----------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Дүрслэл 1 | ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын төлөвлөлт, шилжүүлгийн харьцуулалт                                                   | 7               |
| Дүрслэл 2 | ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдээс авсан санал - төрлөөр                                                                 | 10              |
| Дүрслэл 3 | Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чиг үүрэгт хамаарах байдал                   | 13              |
| Дүрслэл 4 | Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чиг үүрэгт хамаарах байдал                    | 13              |
| Дүрслэл 5 | Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чиг үүрэгт хамаарах байдал | 14              |
| Дүрслэл 6 | ХАА-ны ангилал                                                                                                      | 15              |

|                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|--------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>     | <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А/107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <p><b>Аудитын зорилт</b></p>                     | <p>“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.</p> <p>Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;</li> <li>• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;</li> <li>• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянасан, тайлагнах эсэх асуудлыг тус тус хамруулна.</li> </ul> |
| <p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>             | <p>Аудитад Сангийн яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны Засаг дарга зэрэг байгууллагууд нь аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулсан.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <p><b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p> | <p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийх, тулган баталгаажуулах, ярилцлага хийж, асуулга авах зэрэг арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.</p>                                                                                                                                                                     |
| <p><b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b></p>       | <p>Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, М.Ганбилэг, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын урьдчилсан судалгааны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж, аудитын дэд төлөвлөгөөг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор батлуулж, талбарын үе шатны ажлыг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс гүйцэтгэж, тайланг 2025 оны 07 дугаар сарын 01-ний дотор Дархан-уул аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүллээ.</p>                                                                     |

**БҮЛЭГ 1**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн ч, хуваарийн дагуу олгох нөхцөл бүрдээгүй байна.

1.1. Тайлант онд ОНХНС-ийн орлогын шилжүүлэг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдээгүй нь сумдад орлогыг хуваарийн дагуу олгох нөхцөлийг бүрдүүлээгүй байна. Харин орон нутгийн ИТХ-аар уул уурхайн хандив тусламжаас 5,470.0 сая төгрөгийн орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу төлөвлөсөн байна.

1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг Сангийн яам төвлөрсөн байдлаар тооцон боловсруулдаг тул орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй байна.

1.1.2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу хуваарилж төлөвлөсөн ч зарим тохиолдолд хугацаа хоцроож олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1-д заасны дагуу 3 төрлөөр бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 1. Дорнод аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрийн ангилал /сая төгрөгөөр/

| №                                            | Эх үүсвэр                                   | Орлогын шилжүүлэг | Эзлэх хувь |
|----------------------------------------------|---------------------------------------------|-------------------|------------|
| ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг       |                                             |                   |            |
| 1                                            | АМНАТ 10 хувь (Төсвийн тухай хууль 59.1.21) | 20,009.5          | 78.7       |
| 2                                            | ГТНАТ 30 хувь (Төсвийн тухай хууль 59.1.52) | 2,336.7           | 9.2        |
| 3                                            | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ                 | 2,133.7           | 8.4        |
| Дүн                                          |                                             | 24,479.9          | 96.3       |
| Улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг |                                             |                   |            |
| 1                                            | АМХТЗ 100 хувь                              | 378.9             | 1.5        |
| 2                                            | АМАТЗ 50 хувь                               | 563.2             | 2.2        |
| Дүн                                          |                                             | 942.1             | 3.7        |
| НИЙТ ДҮН                                     |                                             | 25,422.0          | 100.0      |

Эх сурвалж: Дорнод аймгийн ЗДТГ, СТСХ 2024 оны төсөв

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Төсвийн тухай хуульд заасан эх үүсвэрүүдийн хүрээнд нийт 25,422.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Харин Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3-т заасан "орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг" гэж заасан эх үүсвэрээс орлогын шилжүүлэг хийгдээгүй байна.

<sup>1</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 473 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;

<sup>2</sup> газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.


Хүснэгт 2. “Дорнод аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын батлагдсан хуваарь болон шилжүүлсэн хугацаа” /сая.төг/

| №        | Батлагдсан хуваарь | Батлагдсан дүн | Шилжүүлсэн өдөр | Шилжүүлсэн орлого |
|----------|--------------------|----------------|-----------------|-------------------|
| 1        | 2 дугаар сар       | 2,167.38       | 2024-02-22      | 2,167.38          |
| 2        | 3 дугаар сар       | 2,167.38       | 2024-03-28      | 2,167.39          |
| 3        | 4 дүгээр сар       | 2,167.38       |                 | -                 |
| 4        | 5 дугаар сар       | 2,402.90       | 2024-05-01      | 2,080.17          |
| 5        |                    |                | 2024-05-29      | 2,234.35          |
| 6        | 6 дугаар сар       | 2,167.38       | 2024-06-04      | -                 |
| 7        |                    |                | 2024-06-26      | 2,153.00          |
| 8        | 7 дугаар сар       | 2,167.38       | 2024-07-29      | 1,950.96          |
| 9        | 8 дугаар сар       | 2,167.38       | 2024-08-30      | 1,931.91          |
| 10       | 9 дүгээр сар       | 2,562.60       | 2024-09-27      | 2,212.63          |
| 11       |                    |                | 2024-09-30      | 154.99            |
| 12       | 10 дугаар сар      | 2,562.60       | 2024-10-31      | 1,719.49          |
| 13       | 11 дүгээр сар      | 2,327.00       | 2024-11-28      | 2,023.38          |
| 14       | 12 дугаар сар      | 2,562.50       | 2024-12-18      | 1,618.52          |
| 15       |                    |                | 2024-12-19      | 358.64            |
| 16       |                    |                | 2024-12-24      | 1,062.12          |
| 17       |                    |                | 2024-12-24      | 280.33            |
| Нийт дүн |                    | 25,421.86      |                 | 24,115.25         |

Эх сурвалж: Сангийн яам - [ehuulga.mof.gov.mn](http://ehuulga.mof.gov.mn)

Тайлант онд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогыг 2, 3 дугаар сард хугацаанд нь бүрэн шилжүүлсэн боловч 4 дүгээр сард огт шилжүүлээгүй байна. Харин 5 болон 12 дугаар сард 129.5–179.6 хувиар давуулан шилжүүлсэн бол бусад саруудад 67.1–99.3 хувийн биелэлттэй байна.

Дүрслэл 1. “ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын төлөвлөлт, шилжүүлгийн харьцуулалт”

Эх сурвалж: Сангийн яам - [ehuulga.mof.gov.mn](http://ehuulga.mof.gov.mn)

### 1.1.3. Тайлант онд ОНХНС-ийн орлогын шилжүүлэг гүйцэтгэлдээ хүрээгүй нь сумдад орлогыг баталсан хуваарийн дагуу олгох нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангаас 2024 онд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2<sup>3</sup>-д заасан үндэслэл болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар

<sup>3</sup> 59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.



тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-д заасан илтгэлцүүрүүдийг баримтлан хуваарилж, батлагдсан төлөвлөгөөний дагуу олгох 25,422.0 сая төгрөг шилжүүлэхээс 1,306.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

Хүснэгт 3. “Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл” /сая.төг/

| №  | Сумдын нэр   | Төлөвлөсөн      | Гүйцэтгэл       | Зөрүү          |
|----|--------------|-----------------|-----------------|----------------|
|    |              | Дүн             | Дүн             | Дүн            |
| 1  | Баян-Уул     | 719.5           | 695.0           | 24.5           |
| 2  | Баяндун      | 860.7           | 811.0           | 49.7           |
| 3  | Баянтүмэн    | 1,306.0         | 993.8           | 312.2          |
| 4  | Булган       | 476.9           | 452.6           | 24.3           |
| 5  | Гурванзагал  | 400.8           | 387.3           | 13.5           |
| 6  | Дашбалбар    | 1,420.1         | 888.1           | 532.0          |
| 7  | Матад        | 3,732.1         | 3,223.7         | 508.4          |
| 8  | Сэргэлэн     | 409.2           | 325.9           | 83.3           |
| 9  | Хөлөнбуйр    | 318.3           | 307.8           | 10.5           |
| 10 | Хэрлэн       | 2,966.1         | 2,859.6         | 106.5          |
| 11 | Чойбалсан    | 1,160.0         | 1,098.8         | 61.2           |
| 12 | Чулуунхороот | 501.6           | 484.6           | 17.0           |
| 13 | Цагаан-Овоо  | 1,037.2         | 742.3           | 294.9          |
| 14 | Халхгол      | 2,432.8         | 2,147.9         | 284.9          |
| 15 | Аймгийн ОНХС | 7,680.7         | 8,696.8         | (1,016.1)      |
|    | <b>Дүн</b>   | <b>25,422.0</b> | <b>24,115.2</b> | <b>1,306.8</b> |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Тайлант онд ОНХНС-аас орлогын шилжүүлгийг батлагдсан хугацаа, хэмжээнд нийцүүлэн олгоогүй нь шилжүүлгийн хугацааны хэлбэлзэл, гүйцэтгэл дутуу байсантай холбоотой бөгөөд энэ нь аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д орлого хуваарилах, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

#### 1.1.4. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60.2.5-д үндэслэн судалж, уул уурхайн хандив тусламжаас орох 5,470.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөн ИТХ-аар батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт ОНХС-гийн эх үүсвэрийг ОНХНС-гаас олгох шилжүүлэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, малын тоо толгойн албан татварын орлого зэргээс бүрдэхээр заасан.

Аймгийн Засаг дарга нь ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг 25,422.0 сая төгрөг дээр нэмж Төсвийн тухай хуулийн 60.2.5-д заасны дагуу ОНХС-гийн эх үүсвэрийг судлан 2024 онд уул уурхайн хандив тусламжаас орох орлогыг 5,470.0 сая төгрөгөөр төлөвлөн ИТХ-аар батлуулсан байна.

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.

59.2.4.энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.



Хүснэгт 4. “Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт” /мян.төг/

| №          | Үзүүлэлт                                | Сумд            | Аймаг           | Нийт            |
|------------|-----------------------------------------|-----------------|-----------------|-----------------|
| 1          | ОНХНС-ийн санхүүжилт                    | 16,483.5        | 8,938.5         | 25,422.0        |
| 2          | Уул уурхайн хандив, тусламжийн орлогоос | 1,641.0         | 3,829.0         | 5,470.0         |
| <b>Дүн</b> |                                         | <b>18,124.5</b> | <b>12,767.5</b> | <b>30,892.0</b> |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсөв

Хүснэгт 5. “Орон нутгийн хөгжлийн сангийн сумдын орлогын төлөвлөлт” /мян.төг/

| №                  | Үзүүлэлт     | Төлөвлөгөө                                                                   |                                                                                             |                                                                                                   |
|--------------------|--------------|------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|
|                    |              | ИТХ-ын тогтоол<br>Аймгийн 2024 оны<br>төсөв батлах тухай<br>2023.12.04 19/11 | ИТХ-ын тогтоол<br>Аймгийн 2024 оны<br>төсөвт нэмэлт<br>өөрчлөлт оруулах<br>тухай 2024.07.05 | ИТХ-ын тогтоол<br>Аймгийн 2024 оны<br>төсөвт нэмэлт<br>өөрчлөлт оруулах<br>тухай 2024.10.25 02/02 |
| 1                  | Баяндун      | 863.54                                                                       | 860.67                                                                                      | 877.52                                                                                            |
| 2                  | Баянтүмэн    | 1,221.99                                                                     | 1,306.02                                                                                    | 1,330.46                                                                                          |
| 3                  | Баян-Уул     | 719.54                                                                       | -                                                                                           | 734.09                                                                                            |
| 4                  | Булган       | 476.94                                                                       | -                                                                                           | 488.17                                                                                            |
| 5                  | Гурванзагал  | 400.85                                                                       | -                                                                                           | 409.15                                                                                            |
| 6                  | Дашбалбар    | 1,237.60                                                                     | 1,420.08                                                                                    | 1,438.08                                                                                          |
| 7                  | Матад        | 3,732.06                                                                     | -                                                                                           | 3,832.21                                                                                          |
| 8                  | Сэргэлэн     | 432.80                                                                       | 409.16                                                                                      | 417.00                                                                                            |
| 9                  | Халхгол      | 2,432.82                                                                     | -                                                                                           | 2,484.90                                                                                          |
| 10                 | Хөлөнбуйр    | 318.25                                                                       | -                                                                                           | 325.15                                                                                            |
| 11                 | Хэрлэн       | 2,966.08                                                                     | -                                                                                           | 3,037.32                                                                                          |
| 12                 | Цагаан-Овоо  | 1,037.20                                                                     | -                                                                                           | 1,053.98                                                                                          |
| 13                 | Чойбалсан    | 1,159.96                                                                     | -                                                                                           | 1,184.66                                                                                          |
| 14                 | Чулуунхороот | 501.68                                                                       | -                                                                                           | 511.85                                                                                            |
| <b>Сумдын нийт</b> |              | <b>17,501.31</b>                                                             | <b>-</b>                                                                                    | <b>18,124.54</b>                                                                                  |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсөв

Аймгийн 2024 оны ОНХС-д хуваарилагдаж ирэх орлогын шилжүүлэг, уул уурхайн хандив, тусламжийн орлого дээр нэмж бүх сум ОНХС-гийн урьд оны үлдэгдэл болон малын тоо толгойн албан татвараас орох орлогыг төлөвлөж батлуулсан байна.

Хүснэгт 6. “Сумдын Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл” /мян.төг/

| №           | Байгууллагын нэр | Төлөвлөгөө          | Гүйцэтгэл           | Зөрүү             | Биелэлт      |
|-------------|------------------|---------------------|---------------------|-------------------|--------------|
| 1           | Баян-Уул сум     | 199,282.50          | 148,337.80          | 50,944.70         | 74.4%        |
| 2           | Баяндун сум      | 60,000.00           | 60,000.00           | -                 | 100.0%       |
| 3           | Булган сум       | 163,000.00          | 40,301.90           | 122,698.10        | 24.7%        |
| 4           | Баянтүмэн сум    | 60,000.00           | 60,000.00           | -                 | 100.0%       |
| 5           | Дашбалбар сум    | 140,000.00          | 151,960.60          | (11,960.60)       | 108.5%       |
| 6           | Сэргэлэн сум     | 326,201.00          | 277,575.90          | 48,625.10         | 85.1%        |
| 7           | Матад сум        | 47,184.00           | 73,382.20           | (26,198.20)       | 155.5%       |
| 8           | Хөлөнбуйр сум    | 65,000.00           | 65,052.40           | (52.40)           | 100.1%       |
| 9           | Халхгол сум      | 60,000.00           | 60,000.00           | -                 | 100.0%       |
| 10          | Хэрлэн сум       | 28,757.70           | 54,375.10           | (25,617.40)       | 189.1%       |
| 11          | Гурванзагал сум  | 140,000.00          | 119,346.30          | 20,653.70         | 85.2%        |
| 12          | Цагаан-Овоо сум  | 224,000.00          | 170,000.00          | 54,000.00         | 75.9%        |
| 13          | Чойбалсан сум    | 31,706.90           | 21,978.80           | 9,728.10          | 69.3%        |
| 14          | Чулуунхороот сум | 40,000.00           | 75,500.00           | (35,500.00)       | 188.8%       |
| <b>Нийт</b> |                  | <b>1,585,132.10</b> | <b>1,377,811.00</b> | <b>207,321.10</b> | <b>86.9%</b> |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан


Сумдад Малын тоо толгойн албан татварын эх үүсвэр 1,585.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,377.8 сая төгрөгийн 72 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, 86.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

**1.2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.**

**1.2.1. Төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн байна.**

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1<sup>4</sup>, 63.2<sup>5</sup>, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч, урьдчилсан жагсаалт боловсруулан, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, үүний үр дүнд нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхээр хууль, журмаар тодорхойлсон байна.

Дүрслэл 2. “ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдээс авсан санал - төрлөөр”



Эх сурвалж: ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем

Аймгийн хэмжээнд иргэд 2024 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цаасан, цахим болон хэлэлцүүлэг хэлбэрээр өгсөн байна.

Дээрх дүрслэлээс харахад аймгийн хэмжээнд нийт давхардсан тоогоор 166,890.0 саналын 76 хувийг цаасаар, 15 хувийг цахимаар, 19 хувийг хэлэлцүүлгээр авсан байна.

ОНХС-ийн санал авах үйл ажиллагаанд цахим хэлбэрийг ашиглах нь харьцангуй бага, харин уламжлалт буюу цаасан суурьтай санал авах хэлбэр зонхилсон байна.

Хүснэгт 7. “ОНХС-д иргэдийн саналын хэлбэр, тоо”

| №  | Сумын нэр   | Сумын өрхийн тоо | Саналын тоо /хэлбэр/ |                                    |                  | Нийт санал |
|----|-------------|------------------|----------------------|------------------------------------|------------------|------------|
|    |             |                  | Цахимаар             | Хэлэлцүүлэг<br>(бүлгийн ярилцлага) | Цаасан хэлбэрээр |            |
| 1  | Баяндун     | 939              | 413                  | 175                                | 2,587            | 3,175      |
| 2  | Баянтүмэн   | 1203             | 301                  | 190                                | 3,881            | 4,372      |
| 3  | Баян-Уул    | 1532             | 246                  | 961                                | 4,600            | 5,807      |
| 4  | Булган      | 844              | 106                  | 900                                | 3,949            | 4,955      |
| 5  | Гурванзагал | 489              | 57                   | -                                  | 1,916            | 1,973      |
| 6  | Дашбалбар   | 1045             | 2,190                | 4,465                              | 6,517            | 13,172     |
| 7  | Матад       | 1046             | 572                  | -                                  | 504              | 1,076      |
| 8  | Сэргэлэн    | 676              | 106                  | 52                                 | 1,585            | 1,743      |
| 9  | Халхгол     | 939              | 705                  | -                                  | 3,610            | 4,315      |
| 10 | Хөлөнбуйр   | 628              | 312                  | 4,628                              | 3,118            | 8,058      |
| 11 | Хэрлэн      | 13552            | 18,956               | 124                                | 88,908           | 107,988    |
| 12 | Цагаан-Овоо | 1251             | 672                  | 3,947                              | 413              | 5,032      |
| 13 | Чойбалсан   | 833              | 63                   | 269                                | 1,395            | 1,727      |

<sup>4</sup> Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

<sup>5</sup> Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

|          |              |       |        |        |         |         |
|----------|--------------|-------|--------|--------|---------|---------|
| 14       | Чулуунхороот | 656   | 185    | 25     | 1,800   | 2,010   |
| 15       | Аймаг ОНХС   |       |        |        | 1,487   | 1,487   |
| Нийт дүн |              | 25633 | 24,884 | 15,736 | 126,270 | 166,890 |

Эх сурвалж: ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем болон 2024 оны ОНХС-гийн судалгааны нэгтгэл, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Аймгийн 14 сумын 67 багийн 25,633 өрхөөс авсан санал асуулгын тоог харахад иргэдээс саналыг хүртээмжтэй байдлаар авсан байна.

Аймаг, сумд нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 5.5<sup>6</sup>-д заасан хугацаанд багийн алслагдсан иргэдийг хамруулан, цахим болон техник, технологийн боломжийг ашиглан иргэдээс санал авах ажлыг хүртээмжтэй зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.

Харин аймгийн хэмжээнд сум, багийн иргэдээс санал авч эрэмбэлээгүй төлөвлөж, хэрэгжүүлсэн 4,550.3 сая төгрөгийн (Дашбалбар сум 108.6 сая төгрөгийн 2, Баян-Уул сум 60.5 сая төгрөгийн 3, Матад сум 4,364.5 сая төгрөгийн 33, Баянтүмэн сум 16.7 сая төгрөгийн 1) 39 төсөл арга хэмжээ байсныг Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан (Аудитын код:ДОА-2025/001/ШТА-СТА-ТЕЗ)-д тусгаж аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн байна.

### 1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн урт, дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.2.6-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх шаардлагатай.

Энэхүү шаардлагын хүрээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг дараах хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Аймгийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Аймгийн 2024 оны “Хөгжлийн жилийн төлөвлөгөө”.

Аймгийн ХБТХОХ-оос иргэдийн саналыг үндэслэн 2024 онд нийт 15,492.4 сая төгрөгийн санхүүжилт бүхий 89 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эдгээр нь дээрх бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

Мөн тус журмын 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасны дагуу сумдаас ирүүлсэн саналыг нэгтгэх, эрэмбэлэхдээ тухайн сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, үүний үр дүнд сумдын ИТХ-ын тогтоолоор 2024 онд нийт 402 төсөл, арга хэмжээг баталж, эдгээрийг сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцүүлсэн байна.

<sup>6</sup> Энэ журмын 5.2.3-т заасан арга хэлбэрээр санал авах тохиолдолд 30-аас доошгүй хоногийн турш тогтсон цахим хаяг, цахим хуудас, гар утасны программ ашиглан санал өгч буй иргэнийг баталгаажуулах боломжтойгоор ОНХС-ийн саналыг хүлээн авах бөгөөд саналыг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэн баталгаажуулна.

Иймд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээ нь орон нутгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан гэж дүгнэж байна.

### 1.2.3. ОНХС-гийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан 9<sup>7</sup> үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гэж заасан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймгийн хэмжээнд нийт 491 төсөл, арга хэмжээнд 38,448.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн 2024 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

### 1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тухайн шатны чиг үүрэгт нийцүүлэн тусгасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү<sup>8</sup> журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

| Аймгийн түвшин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Сумын түвшин                                                                                                                                                                                                                                                                     |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> <li>- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;</li> <li>- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;</li> <li>- Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;</li> <li>- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;</li> <li>- Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;</li> <li>- Ажлын байр бий болгох;</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;</li> <li>- Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;</li> <li>- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.</li> </ul> |
| <ul style="list-style-type: none"> <li>- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;</li> <li>- Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх;</li> </ul>                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                  |

<sup>7</sup> 1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

2. Сумын иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх; /аймаг/

3. Тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх; /сум/

4. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй байх;

5. Сумын төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;

6. Санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;


7. Санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах;

8. Өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх;

9. ТАХ-ний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах.

<sup>8</sup> Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам

Дүрслэл 3. “Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чиг үүрэгт хамаарах байдал”




Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны ОНХС-ийн судалгааны нэгтгэл

2024 онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 9,054.6 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээ буюу 58 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологийн чиглэл бүхий төсөл, арга хэмжээ эзэлж байна.

Харин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, иргэдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, ажлын байр бий болгох зэрэг эдийн засгийн чадавх бэхжүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээ огт тусгагдаагүй, энэ чиг үүрэгт хамаарах санхүүжилт хуваарилагдаагүй байна.


Дүрслэл 4. “Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чиг үүрэгт хамаарах байдал”



Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны ОНХС-ийн судалгааны нэгтгэл

Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 4,948.3 сая төгрөгийн 76 төсөл, арга хэмжээ буюу 32 хувийг орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах чиглэл бүхий төсөл, арга хэмжээ эзэлж, хамгийн өндөр хувьтай хэрэгжсэн байна. Харин нийт тоо хэмжээгээрээ хамгийн их хувийг 101 төсөл арга хэмжээний 4,162.1 сая төгрөгийн буюу 25 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологийн чиглэл бүхий төсөл арга хэмжээ эзэлж хэрэгжсэн байна.

Дүрслэл 5. “Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чиг үүрэгт хамаарах байдал”



Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны ОНХС-ийн судалгааны нэгтгэл

Сумдын Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх ТАХ-ний 592.4 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ буюу 33 хувийг малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэл бүхий төсөл, арга хэмжээ эзэлж байгаа бол гэмт халдлага, гамшгаас хамгаалах чиглэл бүхий 431.2 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ буюу 24 хувийг эзэлж байна. Харин хортон мэрэгчидтэй тэмцэх /байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/ чиглэл бүхий 1 төсөл, арга хэмжээг 0.37 сая төгрөгөөр төлөвлөн хэрэгжүүлсэн байна.



**БҮЛЭГ 2**


**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 94 хувьтай байна.**

**2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журмыг баримтлаагүй байна.**

**2.1.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.**

Дүрслэл 6. "ХАА-ны ангилал"

Дорнод аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр нийт 415 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарласан байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 98, харьцуулалтын аргаар 99, гэрээ шууд байгуулах аргаар 167 төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан байна. Үлдсэн 54 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлаагүй байна. Энэ нь малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажил, баяр наадмын зардал, урсгал зардлыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.



Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

1. Аймгийн ОНХС-ийн 2023 оны төсөл, арга хэмжээний тендерийн сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгж, компаниудаас нийт 15 гомдол гарч, үүнээс Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 2, Сангийн яаманд хандсан 13 гомдол гарсан нь өмнөх оныхоос 23 хувиар буурсан байна. Үүнд: Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 4, дахин үнэлгээ хийх 9 шийдвэр гарсан байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1<sup>9</sup>-д тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулах, 48 дугаар зүйлийн 48.2.5<sup>10</sup>-д үр дүнг цахим системд нийтлэх, 48.4<sup>11</sup>, 48.5<sup>12</sup>-д баримт бичгийн бүрдлийг ханган архивын нэгж үүсгэх талаар заасан байна.

<sup>9</sup> 11.1.Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

<sup>10</sup> 48.2.5.тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх;

<sup>11</sup> 48.4. Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

48.4.1. санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр;

48.4.2.нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл;

48.4.3.захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;

48.4.4.захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг;

48.4.5.оролцогчдын ирүүлсэн тендер;

48.4.6.үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж;

48.4.7.тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;

48.4.8.захиалагчийн шийдвэр;

48.4.9.худалдан авах гэрээ;

48.4.10.энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг;

48.4.11.бусад баримт бичиг.

<sup>12</sup> 48.5.Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална.



Аймаг, сумдын ОНХС-ийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын баримтуудад хурлын тэмдэглэл, лавлагаа, тодорхойлолт, мэдэгдэл дутуу хавсаргаж, тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулаагүй, худалдан авах ажиллагааны үр дүнг цахим системд дэлгэрэнгүй /шалгарсан аж ахуйн нэгжийн гэрээ, акт/ нийтлээгүй нийтлэг зөрчлүүд илэрч байна.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 27 дугаар зүйлийн дагуу тендерийг үнэлэх талаар заасан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийн шаардлага, шалгуурт заасны дагуу үнэлээгүй дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:

1. Ерөнхий шаардлага хангаагүй буюу НДШ, татварын өртэй аж ахуйн нэгжийг шалгаруулсан 1,197.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. “Эрүүл мэндийн төв болон Эхийн амрах байрны барилгыг хүзүүвчээр холбох засвар (Булган сум), төсөвт өртөг 98.6 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1 дэх “Хуулийн хугацаандаа төлөөгүй, тайлант хугацаанаас хойш өр төлбөрөө төлсөн бол татгалзах үндэслэл болно.” заалтыг хангаагүй буюу 500.0 мянган төгрөгийн НДШ-ийг тайлант хугацаанаас хойш төлсөн байхад “Донж-Өргөө” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
2. “Эрүүл мэндийн төвийн барилгын засвар (Хөлөнбуйр сум), төсөвт өртөг 85.1 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1 дэх “Хуулийн хугацаандаа төлөөгүй, тайлант хугацаанаас хойш өр төлбөрөө төлсөн бол татгалзах үндэслэл болно.” заалтыг хангаагүй буюу 2,490.0 мянган төгрөгийн НДШ-ийг тайлант хугацаанаас хойш төлсөн байхад “Дорнын их өгөөж” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
3. “Цэцэрлэгийн барилгын их засвар (Баяндун сум), төсөвт өртөг 778.7 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1 дэх “Хуулийн хугацаандаа төлөөгүй, тайлант хугацаанаас хойш өр төлбөрөө төлсөн бол татгалзах үндэслэл болно.” заалтыг хангаагүй буюу 1,192.6 мянган төгрөгийн НДШ-ийг тайлант хугацаанаас хойш төлсөн байхад “Орхон нүнжиг” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
4. “Нийтийн орон сууцны барилгын зоорийн давхрын засвар (Хэрлэн сум 8 дугаар баг), төсөвт өртөг 151.5 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1 дэх “Хуулийн хугацаандаа төлөөгүй, тайлант хугацаанаас хойш өр төлбөрөө төлсөн бол татгалзах үндэслэл болно.” заалтыг хангаагүй буюу 534.6 мянган төгрөгийн НДШ-ийг тайлант хугацаанаас хойш төлсөн байхад “Баянлуу” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
5. “Ундны усны худгийн цэвэршүүлэх тоног, төхөөрөмж нэмэгдүүлэх (Матад, Цагаан-Овоо сумдтай хамтран), төсөвт өртөг 84.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.3.3 дахь “Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ.” заалтыг хангаагүй буюу 657.7 мянган төгрөгийн НДШ, 3,483.5 мянган төгрөгийн албан татварын өртэй байхад “Ирмүүн бармат” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

2. Бусад шаардлага буюу тусгай зөвшөөрөл, тендерийн баталгаа, ажлын туршлагатай холбоотой 961.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. “Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, авто машины зогсоолыг нэмэгдүүлэх (Аймгийн хэмжээнд), төсөвт өртөг 544.9 сая төгрөг” төсөл, арга хэмжээний багц 1, 2, 3-ын тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-19.3 дахь “2.8.2.6. Авто замын зогсоол, талбайн тохижилтын ажил хийх засварлах” шалгуурыг хангаагүй буюу тухайн чиглэлийн тусгай зөвшөөрөлгүй “Мянган тэмүүлэл” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

2. “Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног, төхөөрөмж, төсөвт өртөг 277.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-20.1 дэх “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ.” гэсний дагуу НДШ төлөлтийн лавлагаа ирүүлээгүй, ТӨХ-ийн ТШЗ-24.1 дэх “Тендерийн баталгааны дүн: Багц тус бүрийн үнийн дүнгийн 0.5 %-аар тооцно. Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулсан байна.” гэсний дагуу тендерийн баталгаа ирүүлээгүй байхад “Био медикал инженеринг” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
3. “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын автобус (Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль), төсөвт өртөг 140.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-18.1 дэх “Улс болон орон нутгийн хөрөнгөөр санхүүжих 2022, 2023 онуудад тус бүр батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх шаардлагатай ба гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт зэргийг хавсарган ирүүлнэ.” шалгуурыг хангаагүй буюу тухайн чиглэлийн бараа нийлүүлж байсан нь баримтаар нотлогдохгүй байхад “Степпекастле” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

3. Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийн 15.1.1-д мэдээлэл олж авах эрхийг заасан. Харин аудитын явцад дараах аймгийн ОНХС-ийн 5 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт, ААНБ-уудаас ирүүлсэн тендерийн баримт бичгийг ирүүлээгүйгээс дүгнэлт гаргах боломжгүй байна. Үүнд:

- “Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилт, төсөвт өртөг 127.8 сая төгрөг” багц 1-6.
- “Чойбалсангийн гудамжны авто замын засвар, арчлалтын ажил (Хэрлэн сум), төсөвт өртөг 181.0 сая төгрөг”
- “Чойбалсангийн гудамж, “Дорнод НАА” ОНӨААТҮГазрын зүүн талын босоо тэнхлэгийн авто замын арчлалтын ажил (Хэрлэн сум), төсөвт өртөг 184.0 сая төгрөг”
- “Орон нутгийн чанартай 50км авто замын засвар, арчлалт (Хэрлэн сумаас Баян-Уул сумын чиглэлд), төсөвт өртөг 132.9 сая төгрөг”
- “Ундны усыг нэмэгдүүлэх, амьтны амьдрах орчин, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор цооног гаргах, төсөвт өртөг 125.0 сая төгрөг”

4. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичгийн шаардлага, шалгуурт заасны дагуу үнэлээгүй дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:

5. Матад сум нь ерөнхий шаардлага хангаагүй буюу НДШ, татварын өртэй болон бусад шаардлага хангаагүй аж ахуйн нэгжийг шалгаруулсан 733.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. “Тайзны гэрэлтүүлэг (Соёлын төв), төсөвт өртөг 58.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-24.1 дэх “Тендерийн баталгааны дүн: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 0.5 %-аар тооцно.” заалтыг хангаагүй буюу тендерийн баталгаа ирүүлээгүй байхад “Электрон техник” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
2. “Ариун цэврийн байгууламж (Эрүүл мэндийн төв), төсөвт өртөг 142.7 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-24.1 дэх “Тендерийн баталгааны үнийн дүн: Тендерт оролцогч нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 0.5%-аар /713,536 төгрөг/ тооцож ирүүлнэ.” заалтыг хангаагүй буюу тендерийн баталгаа ирүүлээгүй байхад “Гурвангис” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
3. “ЕБС-ийн тоног төхөөрөмж, төсөвт өртөг 38.2 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-24.1 дэх “Тендерийн баталгааны үнийн дүн: Тендерт оролцогч нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 0.5%-аар тооцно.” заалтыг хангаагүй буюу тендерийн баталгаа ирүүлээгүй байхад, ТӨХ-ийн ТШЗ-16.3.3 дахь “Монгол Улсын хуулийн дагуу тухайн тендер нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх шаардлагатай.” заалтыг хангаагүй буюу 994.6 мянган төгрөгийн өртэй байхад “Гантэлмэн” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
4. “Нийтийн ариун цэврийн байгууламж шинээр байгуулах, төсөвт өртөг 172.9 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1.2 дахь “Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон

татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ.” заалтыг хангаагүй буюу 868.5 мянган төгрөгийн өртэй “Чимэрүү” ХХК-г шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

5. “Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулах, төсөвт өртөг 321.2 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1.2 дахь “Монгол Улсын хуулийн дагуу тухайн тендер нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх шаардлагатай.” заалтыг хангаагүй буюу татвар, НДШ төлөлтийн лавлагаа ирүүлээгүй байхад “Соотон чоно” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

6. Халхгол сум нь ерөнхий шаардлага хангаагүй буюу НДШ, татварын өртэй болон бусад шаардлага хангаагүй аж ахуйн нэгжийг шалгаруулсан 670.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. “Буйрын төвд 04квт-ын агаарын шугам, төсөвт өртөг 40.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний батлагдсан зураг, төсөв нь 40.2 сая төгрөг байхад тендерийг зөрүүтэй дүнгээр зарлаж, тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-17.1 дэх “Борлуулалтын орлогын хэмжээ: ТШЗ-ны 17.3-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 80 хувиас багагүй байх” заалтыг хангаагүй буюу борлуулалтыг орлогыг нотлох баримт ирүүлээгүй байхад “Дорнын үндэс” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
2. “Онгоцны буудлын цахилгаан шугам, төсөвт өртөг 100.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний батлагдсан зураг, төсөв нь 100.2 сая төгрөг байхад тендерийг зөрүүтэй, ТӨХ-ийн ТШЗ-19.3-т тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр зарласан байна.
3. “Гэрэлтүүлэг /Төв зам болон туслах/, төсөвт өртөг 230.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээг батлагдсан зураг, төсөвгүй ажлын даалгавраар зарлаж, тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1.2 дахь “Монгол Улсын хуулийн дагуу татвар хураамж төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.” заалтыг хангаагүй буюу татварын 2,374 төгрөгийн өртэй, ТӨХ-ийн ТШЗ-18.1 дэх “Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тухайн ажлын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 80 хувиас багагүй байх” заалтыг хангаагүй буюу борлуулалтын орлогын нотлох баримт ирүүлээгүй байхад “Гантуг констракшн” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
4. “Нийтийн ахуй үйлчилгээний тоног, төхөөрөмж, төсөвт өртөг 80.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.2 дахь “Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.” заалтыг хангаагүй буюу 315.0 мянган төгрөгийн өртэй “Оттомир” ХХК-г шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
5. “Тохижилт замын урд /Хаан банкны зүүн талд/, төсөвт өртөг 90.8 сая төгрөг” төсөл, арга хэмжээний батлагдсан зураг, төсвийн дүн 97.7 сая төгрөг буюу төсвийн дүн зөрүүтэй байхад тендер зарлаж, тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-17.1 дэх “Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын борлуулалтын орлого нь тус бүр батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.” заалтыг хангаагүй буюу 2022-2023 онд 3.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой “Дөчийн харгиа” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
6. “Тохижилт /Найрамдал цэцэрлэгт хүрээлэн/, төсөвт өртөг 50.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн 15.2, 18.1-д заасан НДШ, ижил төстэй ажлын мэдээлэл, техник, хүний нөөцийн чадавхын мэдээллийг ирүүлээгүй байхад “Цөнкөлкөл” ББН-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.
7. “1 орцтой 2 байрны дээвэр засвар, төсөвт өртөг 80.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн 15.2 дахь “Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу ирүүлнэ.” заалтыг хангаагүй буюу 7.6 сая төгрөгийн татварын өртэй “Бүжнэр” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

7. Булган сумын 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гүйцэтгэл нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна. Тухайлбал:

1. “Ариун цэврийн байгууламж (Булган сумтай хамтран), төсөвт өртөг 80.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1.2 дахь “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ.” заалтыг хангаагүй буюу НДШ, татвар, шүүхийн ерөнхий зөвлөл, ШШГ-ын тодорхойлолт ирүүлээгүй, ТӨХ-ийн ТШЗ-24.1 дэх “Тендерийн баталгааны үнийн дүн: Багц2, 3-т тендерийн баталгаа шаардана.” заасныг хангаагүй буюу баталгаа ирүүлээгүй, ТӨХ-ийн ТШЗ-19.3 дахь “Барилга, хот

байгуулалтын яамнаас олгож буй дараах тусгай зөвшөөрөл шаардана. Үүнд: БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1-5 давхар хүртэл) заасныг хангаагүй буюу тусгай зөвшөөрөл ирүүлээгүй байхад “Дорнын мөнгөн хийц” ХХК-ийг шалгаруулж, 2024.12.06-ны өдөр гэрээ байгуулсан байна. Гэтэл Булган сумын 100 жилийн ойн арга хэмжээний үеэр 2 ширхэг ариун цэврийн байгууламжийг “Дорнын мөнгөн хийц” ХХК-иас нийлүүлж, ашиглаж эхэлсэн байна. Энэ нь худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдаагүй бусдад давуу эрх олгосон нөхцөл байдал үүссэн байна.

8. Дашбалбар сумын 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гүйцэтгэл нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна. Тухайлбал:

1. "Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хөдөөгийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Төрийн албан хаагчдын орон сууц, төсөвт өртөг 850.0 сая төгрөг" төсөл, арга хэмжээний тендерийг 2023 онд зарлахдаа түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарлаж, ажлын даалгаварт 8 айлын орон сууц гэж заасан байна. Тендерт "Талын хас констракшн" ХХК 828.6 сая төгрөгөөр шалгарч, гэрээ байгуулж тус ажлыг гүйцэтгэсэн байна. Гэтэл гүйцэтгэлийн явцад тус төсөл, арга хэмжээний зураг, төсвийг 12 айлын орон сууц болгон өөрчилж улсын комисст хүлээлгэж өгсөн байна. Тус компанийн барьсан 12 айлын орон сууцнаас 2024 онд 3 орон сууцыг худалдан авах тендерийг 304.5 сая төгрөгөөр зарлаж, мөн тендерт "Талын хас констракшн" ХХК 304.5 сая төгрөгөөр шалгарч, 2024 онд баригдсан орон сууцнаас төсвийн хөрөнгөөр дахин 3 орон сууцыг худалдан авчээ. Эдгээр нөхцөл байдал нь тус компанид хэт давуу эрх олгохоос гадна хувийн ашиг сонирхол үүссэн байж болзошгүй байна.

## 2.1.2. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн журмын зөвшөөрөхгүй зардалд 2.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг зарцуулсан байна.

Сумдаас Хөлөнбуйр сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулахад зарцуулсан 2.0 сая төгрөгийн зардал нь дэмжлэг, урамшуулал, тэмцээн уралдааны шинж чанартай байх тул энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7-д “Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: 4.7.6-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

## 2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 30 төсөл, арга хэмжээ байгаа нь нийт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 6 хувийг эзэлж байна.

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнээс зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 3,744.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээ байгаа нь нийт бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд харьцуулахад 7.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 8. “Зорилтод үр дүнгийн судалгаа”

| № | Эх үүсвэр    | Зорилтод үр дүнд хүрээгүй ТАХ-ний тоо | ТАХ-ны дүн /мян.төг/ |
|---|--------------|---------------------------------------|----------------------|
|   | Аймгийн ОНХС | 17                                    | 2,917,866.0          |
|   | Сумдын ОНХС  | 13                                    | 827,069.3            |
|   | <b>НИЙТ</b>  | <b>30</b>                             | <b>3,744,935.3</b>   |

Эх сурвалж: ОНХС-ийн нэгдсэн судалгаа

Өмнөх онд зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 54 төсөл, арга хэмжээ байсан бол тайлант онд 30 төсөл, арга хэмжээ болж буурсан байна.



Зорилтод үр дүндээ хүрээгүй шалтгаан нөхцөл нь худалдан авах ажиллагаа зарлагдсан боловч оролцогч байхгүйгээс хэрэгжээгүй, хэрэгжсэн боловч ашиглалт байхгүй байгаатай холбоотой байна.

Тухайлбал: Баянтүмэн сумын ОНХС-ийн 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Агч модны цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт"-ыг хүйтний улиралд гүйцэтгэснээс шалтгаалж чанаргүй хийгдсэн байна. Үүнээс шалтгаалан явган зам, гэрэлтүүлэгт суулт үүсэж, зорилтот үр дүндээ хүрээгүй байна.



### 2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд хувь нэмрээ өгсөн байна.

Аймгийн ОНХС-ийн 1,607.8 сая төгрөгөөр хийгдсэн дараах 3 төсөл, арга хэмжээнүүд орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажлууд болсон байна. Үүнд:

- 1. Хэрлэн суманд "Ягаан цээнэ" өрхийн эмнэлгийн барилгын ажил 547.7 сая төгрөгөөр хийгдэж, Чойбалсан хотын 1-р багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна.
- 2. Усан хангамжийн эх үүсвэрийн Хэрлэн гол доогуурх дюкерийн байгууламж шинэчлэх ажлыг 505.7 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь Чойбалсан хотын иргэд эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангагдаж эхэлсэн байна.
- 3. Чойбалсан хотод шинээр авто зам барих ажлыг 4, 7, 9, 10, 11 дүгээр багт 554.4 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн нь хотын дэд бүтцийг сайжруулахад чухал ажил болсон байна.

Сумдын ОНХС-ийн 5,084.9 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн дараах 33 төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхөөр үр нөлөөтэй ажлууд болсон байна. Үүнд:

#### Хэрлэн сум:

- 1. Хэрлэн сумын 1, 4, 5, 9, 11 дүгээр багуудад хийгдсэн тоглоомын талбай, хүүхэд залуучуудын сагсан бөмбөгийн талбай байгуулах 7 төсөл, арга хэмжээний хүрээнд 736.0 сая төгрөгийг зарцуулж, ашиглалтад оруулсан нь иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэхэд ая тухтай нөхцөлийг бүрдүүлж, хотын өнгө үзэмжид хувь нэмрээ оруулсан байна.
- 2. Хэрлэн сумын 1, 2, 3, 4, 5, 8, 10, 11 дүгээр багуудад 936.5 сая төгрөгөөр хийгдсэн гэрэлтүүлгийн 11 төсөл, арга хэмжээнүүд нь иргэдийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хотын өнгө үзэмжид хувь нэмрээ оруулжээ.
- 3. Хэрлэн сумын 7, 9 дүгээр багуудад 278.8 сая төгрөгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын 4 ажил нь иргэдийн ая тухтай орчинд амьдрах орчныг бүрдүүлсэн байна.

#### Баян-Уул сум:

- Спорт талбайд хиймэл зүлэгжүүлэлтийн ажил 145.9 сая төгрөгөөр хийгдсэн нь иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх ая тухтай байдлыг нэмэгдүүлсэн байна.

#### Баянтүмэн сум:

- Энх хороололд 3х3 сагсны талбай 47.1 сая төгрөгөөр хийгдэж, хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг дэмжсэн ажил болсон байна.

#### Булган сум:

- Хулсан шанд багийн иргэдэд үйлчлэх төвийн барилга 91.5 сая төгрөгөөр баригдаж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэг дороос хүргэх боломжтой болсон байна.

#### Гурванзагал:

- Ерөнхий боловсролын сургуулийн гадна сагсны талбай байгуулах ажлыг 150.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг дэмжсэн ажил болсон байна.

#### Дашбалбар сум:

- Буриадын өв соёлын музей номын сангийн барилга 525.6 сая төгрөгөөр баригдаж, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх боломжтой болсон байна.

**Матад сум:**

- Сумын төвд 980.0 сая төгрөгөөр бетон хучилттай зам тавигдсан нь сумын өнгө үзэмж, дэд бүтцийг нэмэгдүүлсэн ажил болсон байна.

**Сэргэлэн сум:**

- Сумын төвийн нэгдсэн халаалтын шугам сүлжээ 700.0 сая төгрөгөөр шинээр тавигдсан нь иргэд, төрийн байгууллагуудад тав тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Халхгол сум:**

- Сумын төв дэх тохижилтын ажлыг нийт 239.5 төгрөгөөр хийж гүйцэтгэсэн нь сумын өнгө үзэмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Цагаан-Овоо сум:**

- Гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг 56.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Чойбалсан сум:**

- Гудамж талбайн камержуулалтыг 123.2 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Чулуунхороот сум:**

- Жаргалант хороолол руу ЦДАШ татах ажлыг 73.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь дэд бүтцийг нэмэгдүүлсэн байна.

## 2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт зохистой түвшинд байна.

### 2.3.1. Сумын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 285.2 сая төгрөгийн 4 хөрөнгө бүрэн ашиглагдахгүй байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдээс “Үүрэн холбооны сүлжээ, интернэт сайжруулах” (Баянтүмэн, Халхгол, Хэрлэн) төсөл, арга хэмжээний Хэрлэн суманд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь үүрэн холбоо, интернэтийн сүлжээний шугамын ажил хийгдээгүйн улмаас ашиглалтгүй байна.

Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдээс бүрэн ашиглалтгүй 285.2 сая төгрөгийн дараах 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Баяндун сум: “Нийтийн эзэмшлийн ариун цэврийн байгууламж” 184.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь сумын төвийн нэгдсэн цэвэр ус, дулаан дамжуулах шугамын ажил хийгдээгүй нөхцөл байдлаас шалтгаалж ашиглалтгүй байна.
- Баянтүмэн сум: Аудитын явцад “Соёлын төвийн халаалтын засвар” төсөл, арга хэмжээгээр хүлээн авсан хөрөнгийг газар дээр нь үзэхэд 0.8 сая төгрөгийн ус халаагч бойлер ашиглалтгүй байна.
- Булган сум: Аудитын явцад 80.0 сая төгрөгийн “Ариун цэврийн байгууламж” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд ашиглалтгүй байдалтай байна.
- Сэргэлэн сум: Аудитын явцад 20.0 сая төгрөгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх камержуулалт” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд зарим камер нь байгаль цаг уурын нөхцөл байдал, хүний хүчин зүйлээс шалтгаалж ашиглалтгүй байна.

### 2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой түвшинд байна.

Аудитын явцад аймаг, сумдын ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгүүдийг газар дээр нь үзэж шалгахад хүлээн авсан хөрөнгүүд хадгалалт, хамгаалалтын хувьд зохистой түвшинд байна.



**БҮЛЭГ 2**

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.**

**3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

**3.1.1. Аймгийн болон зарим сумдын ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Аймгийн ИТХ хурал болон Хөлөнбуйр, Баянтүмэн, Матад, Цагаан-Овоо сумдын ИТХ нь ОНХС-ийн 2024 оны хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хууль, журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн болон Чойбалсан, Баянтүмэн, Дашбалбар сумдаас бусад сумдын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1 “Засаг даргын болон Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2<sup>13</sup>-р зүйлийн 3.2.2 “Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;”, 3.3<sup>14</sup>-р зүйлийн 3.3.3 “ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;”, 3.4<sup>15</sup>-р зүйлийн 3.4.3 “Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;” гэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

**3.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг сумд хэрэгжүүлээгүй байна.**

Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн байна. Харин сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг 14 сум хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37<sup>16</sup>-р зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4<sup>17</sup>-р зүйлийн 3.4.3 “Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.8 “Захиалагч

<sup>13</sup> Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг

<sup>14</sup> Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг

<sup>15</sup> Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

<sup>16</sup> Захиалагчийн чиг үүрэг

<sup>17</sup> Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.”, 3.4 “Захиалагч барилгын ажлын явц, үе шатанд тавих хяналтыг гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран гэрээний үндсэн дээр өдөр, сар, улирал бүрээр гүйцэтгэнэ.” гэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

### 3.1.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь хэрэгжсэн байна.

Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийг дараах байдлаар ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 9. “Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт”

| №  | Байгууллагын нэр        | Огноо      | Ирүүлсэн албан бичгийн дугаар |
|----|-------------------------|------------|-------------------------------|
| 1  | Баянтүмэн сумын ЗДТГ    | 2024.12.10 | 1/480                         |
| 2  | Баян-Уул сумын ЗДТГ     | 2024.12.10 | 1/396                         |
| 3  | Булган сумын ЗДТГ       | 2024.12.06 | 3/259                         |
| 4  | Гурванзагал сумын ЗДТГ  | 2024.12.19 | 223                           |
| 5  | Дашбалбар сумын ЗДТГ    | 2024.12.12 | 1/425                         |
| 6  | Матад сумын ЗДТГ        | 2024.12.18 | 2/362                         |
| 7  | Сэргэлэн сумын ЗДТГ     | 2024.12.10 | 01/393                        |
| 8  | Халхгол сумын ЗДТГ      | 2024.12.05 | 01/415                        |
| 9  | Хөлөнбуйр сумын ЗДТГ    | 2024.12.12 | 1/157                         |
| 10 | Хэрлэн сумын ЗДТГ       | 2024.12.09 | 1/1286                        |
| 11 | Цагаан-Овоо сумын ЗДТГ  | 2024.12.05 | 1/330                         |
| 12 | Чойбалсан сумын ЗДТГ    | 2024.12.16 | 2/369                         |
| 13 | Чулуунхороот сумын ЗДТГ | 2024.12.16 | 2/183                         |
| 14 | Баяндун сумын ЗДТГ      | 2024.12.12 | -                             |

Эх сурвалж: Дорнод аймаг дахь ТАГ-ын 2024 оны статистик мэдээ

### 3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн байна.

#### 3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн тайлагнаж ажилласан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2 “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.” гэж заасны дагуу сумд ОНХС-ийн хэрэгжилтийг хугацаанд нь, үнэн зөв, иж бүрэн тайлагнаж аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлж ажилласан байна.

#### 3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Аймаг болон сумдын ИТХ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу “Хөрөнгөд бүртгэх тухай” тогтоол гаргаж Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн

төсөл, арга хэмжээг тухайн байгууллагуудад нь шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгуулж ажилласан байна.

### 3.2.3. ОНХС-ийн Удирдлагын нэгдсэн системд сангийн зарцуулалт болон үр дүнгийн талаар үнэн зөв, ил тод нээлттэй мэдээлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг үнэн зөв оруулж, иргэдэд ил тод мэдээлсэн эсэхийг тулгаж үзэхэд:

- Булган сум 19 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийг бүрэн, 1 мэдээллийг дутуу оруулж, 16 мэдээллийг оруулаагүй байна.
- Баянтүмэн сум оруулаагүй 1, дутуу оруулсан 6 мэдээлэл байна.
- Баяндун сум 19 мэдээллийг бүрэн, 1 мэдээллийг дутуу оруулж, хэрэгжээгүй 1 төсөл, арга хэмжээ байна.
- Баян-Уул сум 28 мэдээллийг бүрэн оруулж, хэрэгжээгүй 4 төсөл, арга хэмжээ байна.
- Гурванзагал сум 11 мэдээллийг бүрэн, 1 мэдээллийг дутуу оруулсан байна.
- Дашбалбар сум 6 мэдээллийг бүрэн, 1 мэдээллийг дутуу, 11 мэдээллийг огт оруулаагүй, хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 1 байна.
- Матад сум 45 мэдээллийг огт оруулаагүй байна.
- Сэргэлэн сум 12 мэдээллийг бүрэн, 2 мэдээллийг дутуу оруулж, хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 2 байна.
- Халхгол сум 29 мэдээллийг бүрэн оруулж, хэрэгжээгүй 8 төсөл, арга хэмжээ байна.
- Хөлөнбуйр сум 11 мэдээллийг бүрэн оруулж, огт оруулаагүй 1 мэдээлэл байна.
- Хэрлэн сум 29 мэдээллийг бүрэн, 2 мэдээллийг дутуу оруулж, хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 1 байна.
- Цагаан-Овоо сум 22 мэдээллийг бүрэн оруулж, хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 1 байна.
- Чойбалсан сум 8 мэдээллийг бүрэн, 2 мэдээллийг дутуу оруулж, 3 мэдээллийг огт оруулаагүй, хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 9 байна.

### 3.2.4. Зарим сумд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроосон, огт байршуулаагүй тохиолдол гарсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим сайтад ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулж ажилласан эсэхийг тулган үзэхэд:

- Дашбалбар сум 7, 9-р сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
- Гурванзагал сум жил бүрийн 10-р сарын 01-ний өмнө оруулах мэдээлэл болон 1-12 дугаар сарын мэдээллийг оруулаагүй байна.
- Чулуунхороот сум 1-4 дүгээр сарыг хугацаа хоцроож мэдээлсэн.
- Сэргэлэн сум 7-р сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
- Халхгол сум 2-р сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 “*тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор*”, 6.3.9 “*Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл*.” гэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Тайлант онд ОНХС-ийн орлогын шилжүүлэг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдээгүй нь сумдад орлогыг хуваарийн дагуу олгох нөхцөлийг бүрдүүлээгүйтэй холбоотой байна. Харин Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн ИТХ-аар уул уурхайн хандив тусламжаас 5,470.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөжээ.
2. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулж, иргэдийн саналыг журамд заасны дагуу эрэмбэлсэн нь сайн талтай, төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд ч орон нутгийн урт, дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй бүрэн уялдсан байна.
3. Аймаг, сумдын үнэлгээний хороод нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод, нээлттэй, шударга зохион байгуулаагүйгээс шалтгаалан СЯ-нд 13 удаагийн гомдол гарч, үүнээс гадна 20 тендерт үнэлгээг дутуу хийж гүйцэтгэсэн байна. ОНХС-ийн үйл ажиллагааны журам, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглох заалтад хамаарах 1 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь цаашид анхаарах асуудал болж байна.
4. Зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 30 төсөл, арга хэмжээ байгаа нь нийт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 6 хувийг эзэлж байна. Аймаг, сумын хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн 6,692.7 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулсан байна.
5. Сумдад хэрэгжсэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдээс бүрэн ашиглалтгүй 285.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байна. Харин бусад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хадгалалт, хамгаалалт нь зохистой түвшинд байна.
6. Аймгийн ИТХ хурал болон Хөлөнбуйр, Баянтүмэн, Матад, Цагаан-Овоо сумдын ИТХ нь ОНХС-ийн 2024 оны хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хууль, журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн болон Чойбалсан, Баянтүмэн, Дашбалбар сумдаас бусад сумдын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
7. Төсөл, арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах ажлууд хангалттай хэмжээнд хийгдэж байна. Харин ОНХС-ийн Удирдлагын нэгдсэн системд сангийн зарцуулалт болон үр дүнгийн талаар мэдээлэх ажил хангалтгүй, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроосон болон огт байршуулахгүй байгаа зөрчлүүд гарсаар байна.



| <p align="center"><b>ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАНГИН ГАЗАР</b></p> <p align="center">Баянтүхийн гудамж, 9 дугаар баг<br/>Харын сум, Дорнод аймаг- 21000<br/>Утас: 7058-3440, факс: 7058-4681<br/>Цэвэр усны урсгал: asd@dnrd.gov.mn<br/>Цэвэр хувиас: Dorndgov.mn</p> <p><b>№5.07-01</b>      <b>9/15/20</b></p> <p align="left">тангай _____ -ны №_____</p>                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГУҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА</b></p> <p>Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хийсэн аудитаар ирүүлсэн асуудлын тайлбарыг хүргүүлэв.</p> <p>Хавсралт <b>5</b> хуудастай</p> <div style="text-align: center;"> <br/> <b>БУС ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРЛУУЛАТ БОДЛОГО, ТӨРӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА</b> </div> <p align="right"><b>2125090067</b></p> | <p><b>1.1.2.</b></p> <p>Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1-д заасан дагуу 3 төрлөөр бүрдүүлж шаардлагатай байна. Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Төсвийн тухай хуульд заасан эх үүсвэрудийн хүрээнд нийт 25,422.0 сая төгрөгний аймгийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэхээр төвлөвөж, баталсан байна. Харин Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3-т заасан Орон нутгийн хөгжлийн дамжиг зориулор олгоход дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, "дамжиг" гэж заасан эх үүсвэрээс оронгийн шилжүүлэх хийгдээгүй байна.</p> <p>Тайлант онд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогыг 2, 3 дугаар сард хушцацанд нь буран шилжүүлсэн боловч 4 дүгээр сард огт шилжүүлээгүй байна. Харин 5 болон 12 дугаар сард 129.8–179.6 хувьар давуулан шилжүүлсэн бол бусад саруудад 67.1–99.3 хувийн биелэлттэй, дутуу шилжүүлэлттэй байсан байна.</p> <p>Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангаас 2024 онд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-д заасан үндэслэл болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлан"-д заасан кпптзүүрүүдийг баримтлан хуваариж, батлагдсан төлөвлөгөөний дагуу олгох 25,422.0 сая төгрөг шилжүүлэхээс 1,306.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.</p> <p>Тайлант онд ОНХНС-аас орлогын шилжүүлгийг батлагдсан хугацаа, хэмжээнд нийцүүлэн олгоогүй нь шилжүүлгийн хугацааны хэлбэлзэл, гүйцэтгэл дутуу байсантай холбоотой бөгөөд энэ нь аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д орлого хуваариж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.</p> |
| <p><b>2.1.1. ОНХС-ийн хөрөнгөө</b></p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | <p><b>1.1.3.</b></p> <p>Аймаг, сумдын ОНХС-ийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын баримтуудад журмын тэмдэглэл, лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл дутуу хавсаргасан бөгөөд "Баазм"</p> <p>1.Ерөнхий шаардлага хангаагүй буюу НДШ, татварын өртэй аж ахуйн нэгжийг шалгаруулсан 1,197.9 сая төгрөгийн төсөвт өргөгдөй дараах 5</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

[illegible][illegible]

Тайлангийн 2.1.1 дэх хэсэг буюу худалдан авах ажиллагаатай холбоотой тайлбар нь тухайн үед үнэлгээний хорооны хурлаар шийдэж, шийдвэр гаргасан гэх тайлбарыг өгч байгаа боловч, тендерийн баримт бичигт тусгасан ерөнхий болон техникийн, санхүүгийн, туршлагын шаардлагыг зааж баталсан л бол хүчинтэй баримт бичгийг дагаж мөрдөж, үнэлгээг хийх ёстой байсан. Аудитын явцад ирүүлсэн баримт, материалд үндэслэн дүгнэлт гаргасан тул аудитын шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.

**САНАЛ:****Хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх дараах 2 асуудлыг Үндэсний аудитын газарт уламжилж байна.**

1. Булган сумын 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гүйцэтгэл нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна. Тухайлбал: “Ариун цэврийн байгууламж (Булган сумтай хамтран), төсөвт өртөг 80.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1.2 дахь “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ.” заалтыг хангаагүй буюу НДШ, татвар, шүүхийн ерөнхий зөвлөл, ШШГ-ын тодорхойлолт ирүүлээгүй, ТӨХ-ийн ТШЗ-24.1 дэх “Тендерийн баталгааны үнийн дүн: Багц2, 3-т тендерийн баталгаа шаардана.” заасныг хангаагүй буюу баталгаа ирүүлээгүй, ТӨХ-ийн ТШЗ-19.3 дахь “Барилга, хот байгуулалтын яамнаас олгож буй дараах тусгай зөвшөөрөл шаардана. Үүнд: БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1-5 давхар хүртэл)” заасныг хангаагүй буюу тусгай зөвшөөрөл ирүүлээгүй байхад “Дорнын мөнгөн хийц” ХХК-ийг шалгаруулж, 2024.12.06-ны өдөр гэрээ байгуулсан байна. Гэтэл 2024.07.18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Булган сумын 100 жилийн ойн арга хэмжээний үеэр 2 ширхэг ариун цэврийн байгууламжийг “Дорнын мөнгөн хийц” ХХК-иас нийлүүлж, ашиглаж эхэлсэн байна. Энэ нь худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдаагүй бусдад давуу эрх олгосон нөхцөл байдал үүссэн байна.

2. Дашбалбар сумын 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гүйцэтгэл нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна. Тухайлбал: “Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хөдөөгийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Төрийн албан хаагчдын орон сууц, төсөвт өртөг 850.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний тендерийг 2023 онд зарлахдаа түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарлаж, ажлын даалгаварт 8 айлын орон сууц гэж заасан байна. Тендерт “Талын хас констракшн” ХХК 828.6 сая төгрөгөөр шалгарч, гэрээ байгуулж тус ажлыг гүйцэтгэсэн байна. Гэтэл гүйцэтгэлийн явцад тус төсөл, арга хэмжээний зураг, төсвийг 12 айлын орон сууц болгон өөрчилж улсын комисст хүлээлгэж өгсөн байна. Тус компанийн барьсан 12 айлын орон сууцнаас 2024 онд 3 орон сууцыг худалдан авах тендерийг 304.5 сая төгрөгөөр зарлаж, мөн тендерт “Талын хас констракшн” ХХК 304.5 сая төгрөгөөр шалгарч, 2024 онд баригдсан орон сууцнаас төсвийн хөрөнгөөр дахин 3 орон сууцыг худалдан авчээ. Эдгээр нөхцөл байдал нь тус компанид хэт давуу эрх олгохоос гадна хувийн ашиг сонирхол үүссэн байж болзошгүй байна.

Иймд эдгээр асуудал нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн байж болох тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

**УАГ-Т УЛАМЖИЛЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ САНАЛ:**

1. ОНХНС-аас аймгуудад олгох орлогын шилжүүлгийг хугацаа хоцроох, дутуу шилжүүлэх асуудлууд өнгөрсөн онд гарсан тул шалтгаан нөхцөлийг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар Сангийн яаманд уламжлах. /Хугацаа хоцрох асуудлаас шалтгаалж төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, улирлын шинж чанараас хамаарч огт хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлийг үүсгэж байна./



## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

### **1. Аймгийн ИТХ-ын дарга Г.Цолмонд:**

1. Аймгийн ОНХС-ийн төсөл, арга хэмжээ бүрийн чанар, үр дүнгийн талаар хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох нотлох баримтаар дэмжигдсэн зөвлөмж, дүгнэлт бүхий тайлан бэлтгэж, үр дүнг мэдээлэх ажлыг зохион байгуулах.
2. Сумдын ОНХС-ийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийх ИТХ-ын хяналтыг сайжруулах талаар сумын ИТХ-д чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.

### **2. Аймгийн Засаг дарга Ш.Ёлд:**

1. Цаашид ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг бодит гүйцэтгэлд үндэслэн эрсдэлийг урьдчилан үнэлж, төлөвлөлтөд тусгаж байх.
2. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Сангийн сайдын 2023 оны А/257-А/262 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулж, хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах ажлыг зохион байгуулах талаар аймаг, сумын үнэлгээний хороодод үүрэг чиглэл өгч, үр дүнг эргэн тайлагнах.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүнг сайжруулах арга хэмжээ авах.
4. Жил бүрийн аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт, үр дүнд хийх дотоод аудитын тайланг эхний хагас жилд багтаан ирүүлж байх.

### **3. Баяндун сумын Засаг дарга Б.Батхүүд:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах. /“Нийтийн эзэмшлийн ариун цэврийн байгууламж” 184.4 сая төгрөг/

### **4. Баянтүмэн сумын Засаг дарга П.Гунгаацэрэнд:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах. /“Соёлын төвийн халаалтын засвар” төсөл, арга хэмжээ, 0.8 сая төгрөгийн ус халаагч бойлер/

### **5. Баян-Уул сумын Засаг дарга Д.Баттулгад:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй

ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.

2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

**6. Булган сумын Засаг дарга М.Эрхэмбаатарт:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах. /“Ариун цэврийн байгууламж” төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг 80.0 сая төгрөг/

**7. Гурванзагал сумын Засаг дарга Д.Доржбаатарт:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.3.9-д зааснаар ОНХС-ийн мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллах.

**8. Дашбалбар сумын Засаг дарга Н.Батзоригт:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.3.9-д зааснаар ОНХС-ийн мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллах.

**9. Матад сумын Засаг дарга Э.Саранхүүд:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн

зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

**10. Сэргэлэн сумын Засаг дарга Б.Гантулгад:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах. /“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх камержуулалт” төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
4. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.3.9-д зааснаар ОНХС-ийн мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллах.

**11. Халхгол сумын Засаг дарга Э.Бямбажаргалд:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.3.9-д зааснаар ОНХС-ийн мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллах.

**12. Хөлөнбуйр сумын Засаг дарга Ю.Цэпэлмаад:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

**13. Хэрлэн сумын Засаг дарга С.Мөнжаргалд:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

**14. Цагаан-Овоо сумын Засаг дарга Д.Батмагнайд:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

**15. Чойбалсан сумын Засаг дарга Г.Төрболдод:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн, үнэн зөв, ил тод нээлттэй оруулж иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

**16. Чулуунхороот сумын Засаг дарга Д.Наранбаатарт:**

1. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, төсөвт өртөг өндөртэй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.
2. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.3.9-д зааснаар ОНХС-ийн мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллах.

Аудитаар нийт 5,111.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 2.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, зөрчил арилгуулах 3,613.6 сая төгрөгийн 4 албан шаардлага, 285.2 сая төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өгч ажиллан хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх 1,211.1 сая төгрөгийн 2 саналыг Үндэсний аудитын газарт уламжиллаа.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

**Анхаарах зүйл:** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

  
 ДӨРНОД АЙМАГ ДАХЬ  
 ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
 ТУШААЛ

2025 оны 07 сарын 01  
 4/43

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон аудитад хамрагдсан бусад байгууллагад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.


 Байгууллагын нэр: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар  
 Газар хэлтэс: Завиргаа  
 Албан тушаал: Дарга, Тэргүүлэх аудитор  
 Овог нэр: Баярмалмай Болортуул  
 Зурсан өгнө: 2025.07.01 18:35:08

2125010044

Дарга, Тэргүүлэх аудиторов 2025 оны  
 07 дүгээр сарын 01-ний өдрийн 4/43  
 дүгээр тушаалын хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

| №  | Байгууллагын нэр, албан тушаал | Гүйцэтгэлийн аудитын дугаар | Төлбөрийн акт, албан шаардлагын утга           | Мөнгөн дүн /төгрөгөөр/ |
|----|--------------------------------|-----------------------------|------------------------------------------------|------------------------|
| 1. | Хөлөнбуйр сумын Засаг дарга    | ДОА-2025/31-9-ШТА-ГА        | Төлбөр барагдуулах тухай /Зөвшөөрөхгүй зардал/ | 2,000,000              |
|    | <b>Нийт дүн</b>                |                             |                                                | <b>2,000,000</b>       |

Албан шаардлагын жагсаалт

| №  | Байгууллагын нэр, албан тушаал | Гүйцэтгэлийн аудитын дугаар | Төлбөрийн акт, албан шаардлагын утга | Мөнгөн дүн /төгрөгөөр/ |
|----|--------------------------------|-----------------------------|--------------------------------------|------------------------|
| 1. | Аймгийн Засаг дарга            |                             | Зөрчил арилгах тухай /ХАА/           | 2,159,800,000          |
| 2. | Баянтүмэн сумын Засаг дарга    | ДОА-2025/31-9-ШТА-ГА        | Зөрчил арилгах тухай /Манаргүй ТАХ/  | 50,000,000             |
| 3. | Халхгол сумын Засаг дарга      |                             | Зөрчил арилгах тухай /ХАА/           | 670,800,000            |
| 4. | Матад сумын Засаг дарга        |                             | Зөрчил арилгах тухай /ХАА/           | 733,000,000            |
|    | <b>Нийт дүн</b>                |                             |                                      | <b>3,613,600,000</b>   |

---oOo---



